МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026 · 09 · 28 № 66.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

Гадаад зээл, тусламжийн ашиглалт, үр дүн, хяналт болон өрийн дарамтын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын гадаад зээл, тусламжийн ашиглалт, үр дүн, үр нөлөө, хяналт болон өрийн дарамттай холбоотой дараах асуулгыг тавьж байна.

1.2026 оны 9 дүгээр сарын байдлаарх Монгол Улсын нийт гадаад өр, түүний дотор Засгийн газрын гадаад өрийн хэмжээ;

2.Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний нэр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, ашиглагдаагүй үлдэгдэл хөрөнгийн хэмжээ;

3.Гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээнд Засгийн газар болон холбогдох байгууллагаас хийсэн хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, илэрсэн зөрчил, өгсөн үүрэг, зөвлөмжийн хэрэгжилт;

4.Гадаад зээлээр хэрэгжүүлсэн төслүүдээс ямар бодит үр дүн, үр нөлөө бий болсон талаар;

5. 2026–2035 онд гадаад зээлийн үндсэн төлбөр, хүү болон бусад төлбөр улсын төсөв, өрийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлөх талаар;

6. Цаашид гадаад зээл авахдаа баримтлах шалгуур, нөхцөл, эрсдэлийн үнэлгээний талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Д.БАТБАЯР

2026000196